

## АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН 24 ДҮГЭЭР ХУРАЛ

Аймгийн Засаг даргын Зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 24 дүгээр хуралдааныг 16 цаг 57 минутад Засаг даргын Тамгын газрын II давхрын хурлын танхимд хийж, Зөвлөлийн гишүүдийн 92.3 хувийн ирцтэй хуралдав.

Д/д	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2022 оны зорилтын тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Ховд аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, 2022 оны зорилтын тухай илтгэлийг хэлэлцэх явцад Засаг даргын Зөвлөлийн гишүүдээс гарсан санал, зөвлөмжийг тусган сайжруулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
2	Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийн урьдчилсан дүн, аймгийн 2022 оны төсвийн төслийн тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн 2020 оны төсвийн гүйцэтгэл, 2021 оны батлагдсан төсвийн хэрэгжилтийн урьдчилсан дүн, аймгийн 2022 оны төсвийн төслийн тухай илтгэлийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд үүрэг болгов.
3	Аймгийн газар зохион байгуулалтын 2021 оны төлөвлөгөөний биелэлт, 2022 оны төлөвлөгөөний тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай илтгэлүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадралд үүрэг болгов
4	Аймгийн газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай	ШИЙДВЭРЛЭСЭН нь: Аймгийн газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай илтгэлүүдийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд уламжлахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадралд үүрэг болгов

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР